

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

**СУУРЬ СУДАЛГААНЫ СЭДЭВТ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ,
САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ**

УЛААНБААТАР ХОТ

2007 ОН

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2006 оны 05 дугаар сарын

Дугаар 198

Улаанбаатар хот

30-ны өдөр

Журам батлах тухай

Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогын 3.1, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 22.4, Засгийн газрын 2005 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх журам”-ын 28 дугаар заалтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Суурь судалгааны сэдэвт ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх журам”-ыг хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.
2. Журмын хэрэгжилт, санхүүжилтэд хяналт тавьж, зохицуулж ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн газар (Б.Энхтүвшин)-т даалгасугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулж Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2000 оны “Онолын суурь судалгааны ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх журам” батлах тухай тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ө.ЭНХТҮВШИН

**СУУРЬ СУДАЛГААНЫ СЭДЭВТ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ,
САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэ журмаар суурь судалгааны сэдэвт ажлыг сонгох, шалгаруулах, баталгаажуулах, гүйцэтгэх, санхүүжүүлэх, мэдээлэх, тайлагнах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.
2. Суурь судалгаа дараах үйл ажиллагаанд чиглэгдэнэ.
 - 2.1. Үзэгдэл юмсын зүй тогтлыг тодорхойлох, онолын үндэслэл, шинэ мэдлэг бий болгох;
 - 2.2. дэлхийн шинжлэх ухааны хөгжлийн чиг хандлага, өөрийн орны хөгжлийн онцлог, хэрэгцээ, шаардлага, шинжлэх ухааны хүрсэн түвшинтэй уялдуулан шинжлэх ухааны шинэ салбар, чиглэлийг хөгжүүлэх,
 - 2.3. улс орны эдийн засгийн хөгжлийг хурдасгах, экспортын нөөцийг өсгөж бүтээгдэхүүний үйлдэрлэлийг нэмэгдүүлэх технологи бий болгох онолын үндэслэлийг боловсруулах,
 - 2.4. эх орны эрдэс түүхий эдийн байршил, нөөцийг судлах, ашиглах үндэслэлийг тодорхойлох,
 - 2.5. улс орны түүх, соёл, иргэншил, хэл, утга соёлыг гүнзгийрүүлэн судалж, шинэ мэдлэг бий болгох,
 - 2.6. шинэ материал гарган авах онолын үндэслэл, нано мэдээлэл, технологийн үндэслэлийг боловсруулах,
3. Суурь судалгааны сэдэвт ажлыг гүйцэтгэхэд дараах зарчмыг баримтлана.

- 3.1. суурь судалгааны сэдэвт ажил нь Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого, шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлд нийцсэн байх,
 - 3.2. тухайн шинжлэх ухааны салбараар хийгдэж байгаа суурь судалгаа нь мэдлэгийн хүрсэн түвшинг ахиулсан байх,
 - 3.3. суурь судалгааны сэдэвт ажил нь тухайн салбар ба чиглэлийн хүрээнд урьд нь хийгдсэн болон хийгдэж байгаа ажилтай давхардахгүй байх,
 - 3.4. суурь судалгааны хүрээнд хуримтлагдсан үндэсний оюуны чадавхийг хадгалах, баяжуулах, өвлүүлэн уламжлуулах, судлаачдын залуу халааг төлөвшүүлэх зорилгод нийцсэн байх,
4. Суурь судалгааны сэдэвт ажлыг эрдэм шинжилгээний байгууллага, судлаачдын хамтлаг, эрдэмтэд гүйцэтгэж болно.
5. Суурь судалгааны сэдэвт ажлын дүнд гарч болзошгүй патент, зохиогчийн эрх эзэмших болон эрдэм шинжилгээний тайланг өмчлөх, ашиглах асуудлыг санхүүжүүлэгч, гүйцэтгэгч талууд суурь судалгааны сэдэвт ажил гүйцэтгэх гэрээнд тодорхой заана.

Хоёр. Суурь судалгааны ажлыг дэвшүүлэх сонгох

6. Энэхүү журмын 4-т заасан гүйцэтгэгчид суурь судалгааны сэдэвт ажлын санал дэвшүүлэх эрхтэй.
7. Суурь судалгааны сэдэвт ажлын саналыг дэвшүүлэхдээ энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу сэдэв тус бүрээр “Суурь судалгааны сэдэвт ажлын тодорхойлолт”-ыг боловсруулна.
8. “Суурь судалгааны сэдэвт ажлын тодорхойлолтыг”-ыг холбогдох эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн энэхүү хурлын шийдвэрийн хамт жил бүрийн 5 дугаар сарын 1-ний дотор ШУА-ийн холбогдох бага чуулганд ирүүлнэ.
9. ШУА-ийн бага чуулганд шинээр ирүүлсэн суурь судалгааны сэдвүүдэд 5 дугаар сард багтаан дүгнэлт өгнө. Дүгнэлт өгөхдөө дор дурдсан шалгуурыг үндэс болгоно:

9.1. суурь судалгааг хэрэгжүүлэх эдийн засаг, нийгмийн хэрэгцээ, шаардлага,

9.2. шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлтэй уялдаж байгаа байдал,

9.3. суурь судалгааны сэдэвт ажлыг өөрийн орны эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтдийн хүчээр хэрэгжүүлэх боломж,

9.4. суурь судалгааны сэдэвт ажлыг хэрэгжүүлэхэд шаардагддах лаборатори, туршилтын баазын боломж,

9.5. шинээр гүйцэтгэхээр дэвшүүлж байгаа суурь судалгааны сэдэвт ажлын үр дүнгийн шинэлэг тал, ач холбогдол,

10. ШУА-ийн Бага чуулганаар хэлэлцүүлэн шинээр гүйцэтгэхээр сонгосон суурь судалгааны сэдэвт ажлыг энэ журмын 2 дугаар хавсралтад үзүүлсэн хүснэгтийн дагуу нэгтгэн суурь судалгааны сэдэвт ажлын тодорхойлолт, Бага чуулганы шийдвэрийн хамт Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухайн оны 6 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ.

Гурав. Суурь судалгааны сэдэвт ажлыг шалгаруулах, батлах

11. Суурь судалгааны сэдэвт ажлыг эцэслэн сонгож, дүгнэлт гаргах мэргэжлийн эрдэмтдээс бүрдсэн ажлын хэсгийг Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр байгуулна.

12. Суурь судалгааны сэдэвт үнэлэлт өгч, шалгаруулахдаа дараах шалгуур үзүүлэлтийг баримтална:

12.1. суурь судалгааны сэдэвт ажил нь Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлд хамрагдсан байдал,

12.2. суурь судалгааны сэдэвт ажилд дэвшүүлж байгаа онолын үндэслэл, үзэл баримтлал, аргазүй, бүтээл зэрэг судалгааны үр дүн нь улс орны хөгжлийг түргэсгэх, шинэ салбаруудыг хөгжүүлэх шинжлэх ухааны үндэслэлийг буй болгоход чиглэгдсэн байдал,

12.3. дэлхийн шинжлэх ухааны чиг хандлагатай уялдуулан шинжлэх ухааны шинэ чиглэлүүдийг хөгжүүлэх үндэслэлийг бий болгоход оруулах хувь нэмэр,

12.4. эх орны байгалийн баялгийн байршил, нөөцийг судлах, ашиглах чиглэлийг тодорхойлоход оруулах хувь нэмэр,

12.5. улс орны түүх, иргэншил, хэл, утга соёлын олон чиглэлээр гүнзгийрүүлэн судалж, шинжлэх ухааны шинэ мэдлэгийг бий болгож байгаа байдал,

13. Суурь судалгааны сэдэвт ажилд үнэлэлт өгч, сонгон шалгаруулах ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн дараа оноос шинээр хэрэгжүүлэх суурь судалгааны сэдэвт ажлуудыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Дөрөв. Суурьсудалгааны гэрээт ажлыг гэрээлж баталгаажуулах

14. Суурь судалгааны ажлын сэдвийг санхүүжүүлэгч, гүйцэтгэгч (цаашид "талууд" гэх) энэ журмын 3 дугаар хавсралтаар баталсан "Суурь судалгааны сэдэвт ажлыг гүйцэтгэж, санхүүжүүлэх гэрээ"-ний үлгэрчилсэн загварын дагуу суурь судалгааны сэдэвт ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх гэрээ байгуулна.

15. Суурь судалгааны сэдэвт ажлыг гүйцэтгэгч нь гэрээг 3 хувь үйлдэж санхүүжүүлэгч байгууллага болон шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус бүр нэг хувийг ирүүлнэ.

Тав. Суурь судалгааны сэдэвт ажлыг санхүүжүүлэх

16. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 18.1.1, 20.1.1, 22.4 болон шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журмын 28-д заасныг үндэслэн суурь судалгааны сэдэвт ажлыг санхүүжүүлэхдээ байгууллагыг санхүүжүүлэх, грант олгох хэлбэрийг ашиглана. Суурь судалгааг эрдэм шинжилгээний ажлын зориулалттай зардлын тодорхой хязгаарт багтаан Шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгөөс санхүүжүүлнэ.

17. Шинээр эхлэх суурь судалгааны сэдэвт ажлын санхүүжилтын хэмжээг тодорхойлоход дор дурьдсан зарчим баримтална:

17.1. Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлөөс тогтоосон суурь судалгааны зориулалттай төсвийн зардлын хувь харьцааг үндэслэл болгох,

17.2. эрдэм шинжилгээний хүрээлэнгээс гүйцэтгэх суурь судалгааны сэдэвт ажлыг санхүүжүүлэхдээ эрдэм шинжилгээний ажлын шууд болон тогтмол зардлыг олгох,

17.3. их сургууль, судлаачдын хамтлаг, эрдэмтэдээс гүйцэтгэх суурь судалгааны сэдэвт ажлыг санхүүжүүлэхдээ зөвхөн эрдэм шинжилгээний ажлын шууд зардлыг тооцож олгох,

17.4. гүйцэтгэгч ажлаа энэ журмын 21-д заасны дагуу тайлагнаагүй, ажлын явц байдал, үр дүн нь шаардлага хангахааргүй байвал шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр суурь судалгааны сэдэвт ажлын санхүүжилтыг зогсооно.

**Зургаа. Суурь судалгааны сэдэвт ажлын явцыг хянах,
мэдээлэх, тайлагнах**

18. Суурь судалгааны сэдэвт ажлын онол, арга зүйн хяналтыг холбогдох эрдэм шинжилгээний байгууллагын эрдмийн зөвлөл, санхүүгийн хяналтыг Сан болон эрх бүхий бусад байгууллага тус тус эрхлэн хэрэгжүүлнэ.

19. хяналт тавих эрх бүхий байгууллага хяналт, шалгалтын үйл ажиллагааг дангаараа буюу хамтран хэрэгжүүлж болно.

20. Суурь судалгааны сэдэвт ажлын явц, үр дүнг дор дурьдсанаар мэдээлж, тайлагнана.

20.1. Сэдэвт ажлын удирдагч ажлынхаа явцын тухай мэдээ, тайланг холбогдох эрдэм шинжилгээний байгууллагын эрдмийн зөвлөлд хагас жил, жилээр хэлэлцүүлэх,

20.2. сэдэвт ажлын гэрээт хугацаа дуусмагц үр дүнгийн тайлангаа гүйцэтгэгч холбогдох эрдэм шинжилгээний байгууллагын эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн баримт бичгийн хамт ШУА-ийн салбарын бага чуулганд ирүүлнэ.

20.3. суурь судалгааны сэдэвт ажлын үр дүнгийн тайланг ШУА-ийн бага чуулган хэлэлцэн үнлэлт дүгнэлт гаргаж, нэгдсэн тайланг Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын төв байгууллагад жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан ирүүлнэ.

20.4. сэдэв нь гэрээнд тусгасан үр дүн, зорилтоо бүрэн биелүүлээгүй тохиолдолд түүний шалтгааныг тодорхойлж, цаашид хэрхэн саналыг нэгдсэн тайланд тусгасан байвал зохино.

21. Дууссан ажлын тайлан бичих, түүнийг хүлээлгэн өгөх, хадгалах, хамгаалах, ашиглахтай холбогдсон үйл ажиллагааг Гэгээрлийн сайдын 1998 оны 173 дугаар тушаалаар баталсан "Эрдэм шинжилгээний ажлын тайланг хүлээлгэн өгөх, ашиглуулах журам"-аар зохицуулна.

Суурь судалгааны сэдэвт ажлыг гүйцэтгэх,
санхүүжүүлэх журмын 1 дүгээр хавсралт

СУУРЬ СУДАЛГААНЫ СЭДЭВТ АЖЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

(Үлгэрчилсэн загвар)

Сэдэвт ажлын:

Нэр

Хугацаа (он)

Нийт зардал (мян,төг)

Удирдагч (овог, нэр, эрдмийн зэрэг, цол, албан тушаал)

Сэдэвт ажилд оролцогчид (Овог, нэр, эрдмийн зэрэг, цол, албан тушаал)

Сэдэвт ажлын:

Зорилго

Судлагдсан байдал

Судлах материал, мэдээллийн хангамж, техник-технологийн боломж,

Шинжлэх ухааны шинэлэг тал, ач холбогдол

Сэдэвт ажлаар дэвшүүлэх таамаглал, бүтээл, туурвилын чиглэл

Сэдэвт ажилд оролцогчдын онол, аргазүйн бэлтгэл энэ чиглэлээрх дадлага, туршлага

Тухайн сэдэвт ажлыг гадаадын орон, олон улсын байгууллагатай хамтран явуулах бол энэ талаар урьдчилан хийсэн гэрээ, хэлцэл,

Гадаадтай хамтран явуулах сэдэвт ажлын хүрээнд гадаад хөрөнгийн эх үүсвэр, тоног төхөөрөмж ашиглах боломж гэх мэт

Тодорхойлолт гаргасан:

Толгойлон гүйцэтгэгч байгууллагын захирал..

(Гарын үсэг, овог, нэр)

Сэдэвт ажлын удирдагч.

.
(Гарын үсэг, овог, нэр)

Жич: гарын үсгийг тэмдгээр баталгаажуулна.

Суурь судалгааны сэдэвт ажлыг гүйцэтгэх,
санхүүжүүлэх журмын 2 дугаар хавсралт

20.. онд гүйцэтгэх суурь судалгааны сэдэвт ажлын санал

(Загвар)

Толгойлон гүйцэтгэх байгууллагын нэр.....

20.. оны ... дугаар сарын ...-ны өдөр

No	Сэдэвт ажлын нэр гүйцэтгэх хугацаа	Сэдэвт ажлын удирдагч (Нэр, албан тушаал, эрдмийн зэрэг, цол)	Сэдэвт ажлаар тэвшүүлэх таамаглал, бүтээл, онолын үндэслэл, үзэл баримтлал, зөвлөмж, аргагүй зэрэг үр дүнгүүд	Зардал (мян. төг)	ШУТС-ас хянасан зардал (мян. төг)
1	2	3	4	5	6

Шинээр эхлэх сэдэвт ажлын талаар холбогдох эрдмийн зөвлөлөөс өгсөн дүгнэлт болон үргэлжлэн хийгдэж буй ажлын жил жилийн санхүүжилт, явц, үр дүн, сэдэвт ажилд оролцогчдын тухай дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргана.

Жагсаалтыг:

Үйлдсэн толгойлон гүйцэтгэгч байгууллагын захирал

.....

а/ суурь судалгаанд батлагдсан зардлыг сэдвийн удирдагчийн гаргасан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүлэх,

б/ судалгааны гүйцэтгэл, үр дүн, санхүүжүүлэгчийн талаар гүйцэтгэгчээс тухай бүр мэдээ тайлан гаргуулж авч түүнийг үндэслэн дараагийн үе шатны санхүүжилтыг олгох,

2.2. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг:

а/ судалгааны ажлыг хугацаанд нь бүрэн гүйцэтгэх, дууссан сэдэвт ажлын тайланг хүлээлгэн өгөх,

б/ судалгааны хөрөнгө зардлыг оновчтой хэлбэрээр хуваарилж, үр ашигтай зарцуулах,

в/ санхүүжүүлэгчийн гүйцэтгэлийг сар, улирал бүр тайлагнаж байна.

г/ судалгааны ажлын үр дүнгийн талаар сурталчилж байх,

Гурав. Бусад зүйл

3.1. Энэхүү гэрээний эхийг 4 хувь үйлдэж гэрээлэгч талууд ба шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тус бүр нэг хувийг хадгална.

Санхүүжүүлэгчийг төлөөлж,

.....

(Гарын үсэг)

.....

(Овог нэр)

.....

(Албан тушаал)

Гүйцэтгэгч байгууллагыг төлөөлж,

.....

(Гарын үсэг)

.....

(Овог нэр)

.....

(Албан тушаал)

Сэдэвт ажлын удирадгч:

.....

(гарын үсэг)

.....

(Овог нэр)

.....

(Албан тушаал)

.....нэртэй
суурь судалгааны сэдэвт ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх
200 ...оны дугаар сарын ... ны өдрийн тоот
гэрээний 1 дүгээр хавсралт

**Суурь судалгааны сэдэвт ажлаар дэвшүүлэх таамаглал,
бүтээл, туурвилын тодорхойлолт**

Сэдвээр дэвшүүлэх таамаглал, бүтээл, туурвил	Үр дүнг хүлээлгэн өгөх хугацаа

Санхүүжүүлэгчийг

Гүйцэтгэгчийг

сэдвийн

Төлөөлж

төлөөлж

удирдагч

.....

.....

.....

(гарын үсэг)

(гарын үсэг)

(гарын үсэг)

.....

.....

.....

(овог нэр)

(овог нэр)

(овог нэр)

.....

.....

.....

(Албан тушаал)

(Албан тушаал)

(Албан тушаал)

(Гарын үсгийг тамга дарж баталгаажуулна)

.....нэртэй
 суурь судалгааны сэдэвт ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх
 200...оны дугаар сарын ... ны өдрийн тоот
 гэрээний 2 дугаар хавсралт

Суурь судалгааны сэдэвт ажлаар гүйцэтгэх ажлын төлөвлөгөө

Суурь судалгааны сэдэвт ажлаар гүйцэтгэх тодорхой үе шатны ажлууд	Эхлэх, дуусах хугацаа (он, сар, өдөр)	Гүйцэтгэгчийн овог, нэр, мэргэжил

Санхүүжүүлэгчийг

Гүйцэтгэгчийг

сэдвийн

Төлөөлж

төлөөлж

удирдагч

.....

.....

.....

(гарын үсэг)

(гарын үсэг)

(гарын үсэг)

.....

.....

.....

(овог нэр)

(овог нэр)

(овог нэр)

.....

.....

.....

(Албан тушаал)

(Албан тушаал)

(Албан тушаал)

(Гарын үсгийг тамга дарж баталгаажуулна)

.....нэртэй

суурь судалгааны сэдэвт ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх
200... оны дугаар сарын ... ны өдрийн тоот
гэрээний 2 дугаар хавсралт

Суурь судалгааны сэдэв ажлын өртөг, зардлын тодорхойлолт

- | | |
|--|----------|
| 1. Суурь судалгааны сэдэвт ажлын нийт төсөвт өртөг | мян. төг |
| Үүнээс: урсгал үардал | мян. төг |
| Хөрөнгийн зардал | мян. Төг |
| 2. Нийт зардлын оны хуваарь (урьдчилсан байдлаар) | |

он	Бүгд	Урсгал	Хөрөнгийн	ШУТС-аас санхүүжүүлэх зардал
200..				
200..				
200..				
Дүн				

3. Шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгийн батлагдсан хэмжээ, жилийн төсөв, төлөвлөгөөтэй уялдуулан дээр дурьдсан оны хуваарьт жил бүр өөрчлөлт, тодотгол хийнэ.

Санхүүжүүлэгчийг	Гүйцэтгэгчийг	сэдвийн
Төлөөлж	төлөөлж	удирдагч
.....
(гарын үсэг)	(гарын үсэг)	(гарын үсэг)
.....
(овог нэр)	(овог нэр)	(овог нэр)
.....
(Албан тушаал)	(Албан тушаал)	(Албан тушаал)

(Гарын үсгийг тамга дарж баталгаажуулна)

